

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын -ны өдөр

Улаанбаатар хот

## ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1.1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.Энэ хуулийн зорилт нь нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор явуулах хууль сахиулах ажиллагааны үндэслэл, журмыг тогтоох, энэхүү ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад оршино.

#### 1.2 дугаар зүйл.Хууль сахиулах ажиллагааны тухай хууль тогтоомж

1.Хууль сахиулах ажиллагааны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Эрүүгийн хууль<sup>2,3</sup>, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

#### 1.3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

1.Хууль сахиулах ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээг баримтална.

2.Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль сахиулах ажиллагаа явуулахад энэ хуульд заасан журмыг баримтална.

3.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт хууль сахиулах ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.

4.Хуульд заасан тохиолдолд хууль сахиулах ажиллагаанд мөрдөх заавар, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор хамтран, эсхүл дангаар батална.

5.Улсын хил хамгаалах байгууллагын алба хаагч, улсын байцаагч, байгаль хамгаалагч энэ хуульд заасан тохиолдолд хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

---

1 Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

2 Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2016 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

6.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг тус тусын хуулиар тогтооно.

#### **1.4 дүгээр зүйл.Хууль сахиулах ажиллагааны зарчим**

1.Хууль сахиулах ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна шуурхай байх, нууцыг хамгаалах зарчмыг баримтална.

#### **1.5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.1“нийтийн эмх замбараагүй байдал” гэж хүний амь нас, эрүүл мэнд, олон нийтийн аюулгүй байдалд хохирол учруулахуйц түйвээн үймүүлэх, эвдэн сүйтгэх, галдан шатаах, эд хөрөнгө устгах, хууль бусаар галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, аюултай бодис хэрэглэх, хууль сахиулагчийг зэвсэглэн эсэргүүцэх, нийтийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан хориг саад босгох зэрэг нөхцөл байдал бий болсныг;

1.2.“хамгаалах хүн” гэж Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүнийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн<sup>3</sup> 3.1.4-д заасан хүнийг;

1.3.“хувийн баримт бичиг” гэж Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, албаны болон жолоодох эрхийн үнэмлэх, гадаадын иргэний паспорт, эсхүл тэдгээртэй адилтгах баримт бичгийг;

1.4.“хууль сахиулах ажиллагаа” гэж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор явуулах энэ хуульд заасан ажиллагааг;

1.5.“нийтийн хэв журам сахиулах” гэж гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журмыг сахиулах үйл ажиллагааг;

1.6.“олон нийтийн аюулгүй байдлыг хангах” гэж хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт хохирол, хор уршиг учруулж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажиллагааг;

---

3 Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2003 оны 44 дугаарт нийтлэгдсэн.

2.Энэ хуульд хэрэглэсэн бусад нэр томъёог Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан утгаар ойлгоно.

### **1.6 дугаар зүйл.Хууль сахиулах ажиллагааны хэл, бичиг**

1.Хууль сахиулах ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан ёсны хэл, бичгээр хөтөлж, баримтжуулна.

2.Монгол хэл мэдэхгүй хүн өөрийн эх хэл болон мэдэх хэл, бичгээр, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтай хууль сахиулах ажиллагаанд оролцох эрхээр хангагдана.

### **1.7 дугаар зүйл.Хууль сахиулах ажиллагааны нууцлал**

1.Прокурор, хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай зарим ажиллагааны төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллана.

2.Прокурор, хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд, хууль сахиулах ажиллагааг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн хувь хүн, байгууллага, төрийн нууцыг задруулахгүй байх, түүнийг хамгаалах арга хэмжээ авна.

3.Прокурор, хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд нь хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулна.

### **1.8 дугаар зүйл.Хууль сахиулах ажиллагааны мэдээлэл өгөх**

1.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд, энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэхдээ нэр, албан тушаалаа танилцуулж, албаны үнэмлэхээ үзүүлж, дараахь мэдээллийг өгнө:

1.1.явуулах ажиллагаа, түүний үндэслэл;

1.2.прокурорын зөвшөөрлөөр явуулах ажиллагаанд зөвшөөрлийг танилцуулах;

1.3.хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн үйлдэл хийсэн бол албадлага хэрэглэх, хуулийн хариуцлага хүлээлгэх тухай сануулах.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийг ажиллагаа эхлэхийн өмнө, боломжгүй бол ажиллагааны явцад, эсхүл ажиллагааг дууссаны дараа өгч болно.

3.Хууль сахиулах ажиллагааг хоёр, буюу түүнээс олон хүнд нийтэд нь, эсхүл хоёр,буюу түүнээс дээш төрлийн ажиллагааг нэгэн зэрэг явуулах бол энэ зүйлд

заасан мэдээллийг нэг удаа өгч болно. Хууль сахиулах ажиллагааг багаар гүйцэтгэх бол зөвхөн багийн ахлагч өөрийгөө танилцуулна.

4.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны үед энэ зүйлийн 1.3-т заасан мэдээллийг дангаар нь өгч болно.

5.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд, эрх бүхий албан тушаалтан хууль сахиулах ажиллагааны эцсийн шийдвэр гарах хүртэл тухайн хүн, хуулийн этгээдийг илтэд буруутган олон нийтэд мэдээлэхийг хориглоно.

### **1.9 дүгээр зүйл.Хууль сахиулах ажиллагааг хамтран хэрэгжүүлэх**

1.Хууль сахиулах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага энэ хуульд заасан ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараахь хэлбэрээр хамтран ажиллаж болно:

- 1.1.мэдээлэл солилцох, гаргуулан авах;
- 1.2.харилцан дэмжлэг авах, үзүүлэх;
- 1.3.тодорхой ажиллагааг хамтран хэрэгжүүлэх.

2.Хууль сахиулах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага нь энэ хуульд заасан ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүн, хуулийн этгээдтэй хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллаж болно.

### **1.10 дугаар зүйл.Хууль сахиулах ажиллагаанд хяналтын төхөөрөмж ашиглах**

1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дууны, дүрсний, дуу-дүрсний төхөөрөмж ашиглаж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан төхөөрөмжид тавигдах шаардлага, хэрэглэх журмыг Засгийн газар батална.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмын дагуу баримтжуулагдсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтаар ашиглаж болно.

### **1.11 дүгээр зүйл.Гомдол шийдвэрлэх**

1.Хууль сахиулах ажиллагааны явцад хууль, журмыг зөрчсөн тухай гомдлыг ажиллагааг явуулсан байгууллагад гаргана.

2.Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ. Нэмэлт баримт шалгах, эсхүл шаардлагатай бусад ажиллагааг явуулах бол тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хугацааг ажлын 5 хүртэл өдрөөр сунгаж болно.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан албан тушаалтны гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор прокурорт гомдол гаргаж болно.

4.Прокурор энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэж, хариуг бичгээр өгнө.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ САХИУЛАХ НИЙТЛЭГ АЖИЛЛАГАА**

### **2.1 дүгээр зүйл.Шаардлага тавих**

1.Хуульд заасан чиг үүргийн хүрээнд хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд, хүн, хуулийн этгээдэд шаардлага тавина.

2.Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн ажилтан нийтийн хэв журмыг зөрчсөн, зөрчиж болзошгүй согтуурсан, мансуурсан байдалтай хүнийг олон нийтийн газрыг орхин явахыг шаардаж болно.

3.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд, хоёр ба түүнээс олон хүнд шаардлага тавих тохиолдолд хүн тус бүрт давтан хэлэх үүрэг хүлээхгүй.

4.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээдийн шаардлагыг тухайн хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

5.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээдийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, эсхүл хуулийн дагуу явуулж байгаа ажиллагаанд нь саад учруулсан бол албадан гүйцэтгэж, хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **2.2 дугаар зүйл.Баримт бичиг шалгах**

1.Хуульд заасан чиг үүргийн хүрээнд хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд дараахь тохиолдолд хүний баримт бичгийг шалгана:

1.1.гэмт хэрэг, зөрчил үйлдсэн байж болзошгүй сэжиг бүхий хүн, зөрчил гарсан цаг хугацаанд тухайн газар, эсхүл түүний ойролцоо байсан хүн, хэргийн талаар мэдээлэлтэй байж болох хүн;

1.2.гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, үйлдэгдсэн байж болзошгүй тодорхой газар болон түүний ойр орчимд, эсхүл бусад газар сэжигтэй байдалтай байгаа хүн;

1.3.гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн газар, эсхүл хамгаалалт, хяналтын бүс, объектод хүн, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх шаардлагатай бол;

1.4.албадлагын арга хэмжээ авагдсан хүн хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэх үндэслэл бүхий сэжиг байгаа бол;

1.5.баривчлагдах, эрэн сурвалжлагдаж байгаа хүн мөн эсэхийг тогтоох бол;

1.6.хууль тогтоомжид заасан хамгаалалтад байгаа бүс, объектод хууль бусаар нэвтрэн орохыг завдсан этгээд хэн болохыг тогтоох;

1.7.согтуурсан, мансуурсан байдалтай, хорт бодист хордсоны улмаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон хүнийг хэн болохыг тогтоох.

2.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд хүний хувийн баримт бичгийг шалгахдаа нүүрээ хаасан зүйлийг авах, нүүрээ халхлах аливаа үйлдэл хийхгүй байхыг шаардах, нэр, хаяг, зөвшөөрлийн бүртгэлийг шалгах, эд зүйл, баримт бичиг нь гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан, эсхүл үйлдэх замаар олж авсан эсэхийг тодруулах ажиллагааг явуулна.

3.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд нь хүний хувийн баримт бичгийг шалгахдаа ажиллагааг дуустал түүнийг тухайн газраас явахыг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагад очиж шалгуулах шаардлага тавьж болно.

4.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд шаардсан бол тухайн хүн хувийн баримт бичгээ шалгуулах үүрэгтэй.

5.Баримт бичиг шалгах ажиллагаа явуулсан нь нэгжлэг хийсэнд тооцогдохгүй.

6.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд нь хүний баримт бичгийг шалгаж, шаардлагатай гэж үзвэл дараахь ажиллагааг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд явуулна:

6.1.амиа хорлохыг завдсан, өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй, эсхүл сэтгэцийн эмнэлгээс оргосон хүнийг эмнэлгийн байгууллагад хүлээлгэн өгөх;

6.2.шүүхийн шийдвэрээр албадан эмчлүүлж байгаа хүн оргон зайлсан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа бол баривчлах, саатуулах, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэж өгөх;

6.3.хараа хяналтгүй, оршин суугаа газрын хаяг, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тодорхойгүй, эсхүл согтуурсан, мансуурсны улмаас өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй болсон хүнтэй хамт яваа бага насны хүүхэд, эрх зүйн бүрэн чадамжгүй хүнийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгөх;

6.4.согтуурсан, мансуурсан, хордсон байдалтай хүн өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон бол хамгаалах хүнд, эсхүл эмнэлгийн байгууллагад, эсхүл цагдаагийн байгууллага, эрүүлжүүлэх байранд хүлээлгэн өгөх;

6.5.зөрчил үйлдсэн хүний нэр, хаягийг тогтоох зорилгоор хуульд заасан хугацаагаар саатуулах, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгөх;

6.6.гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл байгаа бол баривчлах, эсхүл эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэж өгөх;

6.7.хамгаалалт, хяналтын бүс, объектод нэвтрүүлэхээс татгалзах, нэвтрүүлэхгүй байх.

### **2.3 дугаар зүйл.Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах**

1.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд, хуулийн этгээдийн бүртгэл, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, холбогдох бусад баримт бичгийг дараахь тохиолдолд шалгана:

1.1.хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа;

1.2.хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа талаар гомдол, мэдээлэл хүлээн авсан.

2.Энэ зүйлд заасан баримт бичгийг хууль ёсны эсэхийг шалгах шаардлагатай бол ажлын 5 өдөр хүртэлх хугацаагаар хураан авч болно.

### **2.4 дүгээр зүйл.Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах**

1.Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийг дараахь тохиолдолд зогсоон шалгана:

1.1.замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дүрэм зөрчсөн;

1.2.стандартын шаардлага хангаагүй, хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бүрэн бус тээврийн хэрэгсэл;

1.3.жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодож яваа байдал нь бусдын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй;

1.4.тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх журам зөрчсөн;

1.5.эрэн сурвалжлагдаж байгаа тээврийн хэрэгсэл, эсхүл тээврийн хэрэгсэлд гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан, хууль бусаар олж авсан эд зүйл, барааг тээвэрлэж байгаа гэх үндэслэл бүхий сэжигтэй бол;

1.6.баривчлагдах, эрэн сурвалжлагдаж байгаа этгээд жолоодож, эсхүл түүгээр зорчиж яваа гэх үндэслэл бүхий сэжигтэй бол;

1.7.согтуурсан, мансуурсан байдалтай хүн жолоодож яваа гэх үндэслэл бүхий сэжигтэй бол;

1.8.хүний амь нас, эрүүл мэндэд шууд хохирол учруулах эд зүйлийг хууль бусаар тээвэрлэсэн гэх үндэслэл бүхий сэжигтэй бол;

1.9.гэмт хэрэг таслан зогсоох зорилгоор.

2.Автотээврийн улсын байцаагч энэ зүйлийн 1.2, 1.3, 1.7-д заасан үндэслэлээр нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийг, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч энэ зүйлийн 1.5-д заасан, улсын хил хамгаалах байгууллагын алба хаагч энэ зүйлийн 1.5, 1.6, 1.9-д заасан үндэслэлээр тээврийн хэрэгслийг зогсоон шалгаж болно.

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагч энэ зүйлийн 1.5, 1.6-д заасан үндэслэлээр тээврийн хэрэгслийг зогсоон шалгаж болно.

4.Тээврийн хэрэгслийг зогсоох дохиог ойлгомжтой байдлаар өгч, энэ хуулийн 1.8 дугаар зүйлд заасны дагуу өөрийгөө танилцуулан шалгах үндэслэлийг тайлбарлана.

5.Жолооч, зорчигч, тээврийн хэрэгслийг дараахь хэлбэрээр шалгана:

5.1.жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бусад холбогдох баримт бичгийг тулгах, шаардлагатай бол зорчигчийн баримт бичгийг шалгах;

5.2.техникийн стандартын шаардлага хангасан, тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх эрхтэй эсэхийг шалгах;

5.3.жолоочийг согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг шалгах;

5.4.тээврийн хэрэгсэлд үзлэг хийх.

6.Зогсох дохио, шалгуулах шаардлагыг биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн бол энэ хуульд заасны дагуу албадлага хэрэглэх үндэслэл болно.

## **2.5 дугаар зүйл.Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах**

1.Хууль сахиулах чиг үүргийн хүрээнд цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын алба, улсын хил хамгаалах байгууллагын алба хаагч хүний согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг дараахь аргаар шалгаж болно:

1.1.харилцан ярилцах аргаар сэтгэцийн байдал, хэл ярианы өөрчлөлт, нүдний хүүхэн харааны хэвийн байдлыг магадлах;



1.2. шулуун шугамын дагуу өөрийнх нь зөвшөөрснөөр алхуулж, тэнцвэрээ олж байгаа эсэхийг магадлах;

1.3. зориулалтын тусгай багаж, хэрэгслээр шалгах.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг тогтоосон дүгнэлтийг тухайн хүнд газар дээр нь танилцуулна.

3. Шалгуулсан хүн энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй бол 24 цагт багтаан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шинжилгээ хийлгэхээр биологийн дээж өгч болно.

## **2.6 дугаар зүйл. Жолооч согтуурсан, мансуурсан байдалтай байгаа үед авах арга хэмжээ**

1. Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч согтуурсан, мансуурсан байдалтай байгаа жолоочид дараахь арга хэмжээг авна:

1.1. тээврийн хэрэгсэлд үзлэг хийх;

1.2. хуульд заасан үндэслэл байгаа бол эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах;

1.3. тээврийн хэрэгслийг шилжүүлэн байрлуулах, эсхүл хөдөлгөөнийг хязгаарлах;

1.4. тухайн хүн, тээврийн хэрэгслийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэж өгөх.

## **2.7 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, түр саатуулах**

1. Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч дараахь тохиолдолд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, эсхүл тээврийн хэрэгслийг түр саатуулж болно:

1.1. тухайн тээврийн хэрэгслийг эрэн сурвалжилж байгаа бол;

1.2. жолоочийг гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах бол;

1.3. жолоодох эрхгүй, ангилал тохирохгүй үнэмлэхтэй хүн жолоодож явсан бол;

1.4. улсын дугаар, бүртгэлийн зөрчилтэй бол;

1.5. хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бүрэн бус тээврийн хэрэгслийг;

1.6. согтуурсан, мансуурсан байдалтай байгаа жолоочийн тээврийн хэрэгслийг.

2. Хуульд заасан чиг үүргийн хүрээнд улсын хил хамгаалах байгууллагын алба хаагч энэ зүйлийн 1.2-т заасан үндэслэлээр тээврийн хэрэгслийг түр саатуулж болно.

3.Түр саатуулах тээврийн хэрэгслийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл бусад аргаар хөдөлгөөнийг хязгаарлана.

## **2.8 дугаар зүйл.Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх**

1.Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийг дараахь тохиолдолд зөөж шилжүүлж болно:

1.1.замын хөдөлгөөний дүрэмд заасан түр, эсхүл удаан зогсохыг хориглосон газарт зайлшгүй зогсолтоос бусад хэлбэрээр зогссон;

1.2.хориглолт тогтоосон, эсхүл мэдээлэх тэмдэг, тэмдэглэл бүхий замын зорчих хэсэг дээр зогссон;

1.3.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх үед;

1.4.шаардлагатай бол энэ хуулийн 2.7 дугаар зүйлийн 1.3-т заасан тохиолдолд.

2.Шилжүүлэн байрлуулах тээврийн хэрэгслийг зориулалтын техник хэрэгсэл ашиглан энэ хуулийн 2.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан газарт хуульд заасны дагуу хүргэнэ.

## **2.9 дүгээр зүйл.Согтуурсан, мансуурсан байдалтай хүнд авах арга хэмжээ**

1.Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд хуульд заасан үндэслэл байгаа бол согтуурсан, мансуурсан байдалтай хүнийг эрүүлжүүлэх, эсхүл эмнэлгийн байгууллагад хүлээлгэн өгнө.

2.Дор дурдсанаас бусад тохиолдолд согтуурсан, мансуурсан хүнийг хамгаалах хүнд нь хүлээлгэн өгнө:

2.1.догшин хэрцгий авирлаж, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй;

2.2.хамгаалах хүн хүлээн авахаас татгалзсан;

2.3.Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5.1-д заасан үндэслэл байгаа бол.

3.Согтуурсан, мансуурсан байдалтай хүн зөрчил үйлдсэн гэх үндэслэлтэй бол хуульд заасан журмын дагуу саатуулан шалгах, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

## **2.10 дугаар зүйл.Зорчих хөдөлгөөнийг хязгаарлах**

1.Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч хүн, тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг дараахь тохиолдолд хязгаарлаж болно:

1.1. аюултай орчин, хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд нэвтрэх үед;

1.2. нийтийн эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, жагсаал, цуглааныг албадан тараах үед;

1.3. эрэн сурвалжлагдаж байгаа хүнийг баривчлах, мөрдөн хөөх үед;

1.4. террор үйлдэх, хүний амь нас, эрүүл мэндэд аюул, орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис, бусад эд зүйл байна гэх мэдээллийг шалгах үед;

1.5. төрийн тусгай хамгаалалтын бүс тогтоосон үед.

2. Цагдаагийн алба хаагч зорчих хөдөлгөөнийг биечлэн, эсхүл тууз, хаалт байрлуулах зэргээр хязгаарлаж болно.

3. Зорчих хөдөлгөөнийг хязгаарласан тохиолдолд оршин суугчдын амьдралын хэвийн нөхцөлийг хангах бололцоотой арга хэмжээг авах, иргэдэд зорчих чиглэлийн талаар мэдээлнэ.

### **2.11 дүгээр зүйл. Зам чөлөөлөх, хөдөлгөөний чиглэлийг түр өөрчлөх, хаах**

1. Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч зам чөлөөлөх, хөдөлгөөний чиглэл, урсгалыг түр өөрчлөх, хаах арга хэмжээг дараахь тохиолдолд авч болно:

1.1. төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжийн дагуу үүрэг гүйцэтгэх;

1.2. энэ хуулийн 3.1, 3.2, 3.3 дугаар зүйлд заасан ажиллагааг явуулах;

1.3. хуульд заасан бусад.

2. Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг өөрчлөх, хаах шийдвэр цуцлагдсаны дараа явган зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг биечлэн зохицуулж, хөдөлгөөнийг хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна.

### **2.12 дугаар зүйл. Орон байр, бусад газарт нэвтрэн орох**

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр бусдын орон байр, бусад газарт нэвтрэн орохдоо хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, энэ зүйлд заасан журмыг баримтална.

2. Нэвтрэн ороход оршин суугч, эзэмшигчид нэвтрэн орох үндэслэлээ тайлбарлаж, саад учруулбал эсэргүүцлээ зогсоохыг шаардаж, албадлага хэрэглэхийг анхааруулна.

3.Хойшлуулшгүй тохиолдолд бусдын орон байр, бусад газарт нэвтрэн орох бол энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан анхааруулгыг өгөхгүй байж болно.

4.Нэвтрэн ороход эд зүйл, цоож, түгжээ, байгууламжийн хэсгийг эвдэх, дохиолол, хяналтын систем, цахилгааныг салгах, нохой, бусад амьтныг номхотгох, техник хэрэгсэл ашиглах зэргээр учрах саадыг арилгаж болно.

5.Оршин суугч, эзэмшигчийн эзгүйд нэвтрэн орохдоо оршин суугч, эзэмшигчид нь даруй мэдэгдэх, боломжгүй бол 24 цагийн дотор мэдэгдэх арга хэмжээ авна.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар оршин суугч, эзэмшигчид нь мэдэгдэх боломжгүй бол түүний оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.

7.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан арга хэмжээ авсан, эсхүл эзэмшигчийнх нь эзгүйд нэвтрэн орсон бол эвдэрсэн эд хөрөнгийн хэвийн байдлыг сэргээх, түр хугацаагаар хамгаалах арга хэмжээ авна.

8.Дор дурдсан тохиолдолд орон байр, бусад газарт нэвтрэн орохдоо албадлага хэрэглэж болно:

8.1.гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн даруйд нь мөрдөн хөөж баривчлах;

8.2.энэ хуулийн 2.14 дүгээр зүйлд заасны дагуу гэмт хэргийн талаархи мэдээллийг шалгахад гэмт хэрэг үйлдэгдсэн гэх сэжиг бүхий үндэслэл байгаа бол;

8.3.эрэн сурвалжлагдаж байгаа хүн, оргон зайлсан, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ял шийтгүүлсэн хүн, хоригдлыг мөрдөн хөөж баривчлах бол;

8.4.энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлийн дагуу нэвтрэн ороход саад учруулсан, эсэргүүцсэн бол.

## **2.13 дугаар зүйл.Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох**

1.Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор бусдын орон байранд нэвтрэн орж, дараахь ажиллагааг явуулж болно:

1.1.хохирогч болон гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан журмын дагуу аюулын зэргийн үнэлгээ хийж, түүнийг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотных нь хүний хамгаалалтад өгөх;

1.2.хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардах;

1.3. аюулын зэрэг өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа нийгмийн ажилтанд мэдэгдэх;

1.4. хохирогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаархи мэдээллийг бичгээр өгөх;

1.5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.1.8-д заасан хохирогчийн эрхийг хамгаалах арга хэмжээ авах;

1.6. шаардлагатай бол хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах;

1.7. галт зэвсэг, хүчирхийлэл үйлдэхэд ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авах.

2. Цагдаагийн алба хаагч шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн хүн, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд<sup>4</sup> заасан арга хэмжээг авна.

3. Энэ зүйлийн 1.2-т заасан шаардлагыг хүчирхийлэл үйлдэгч биелүүлэхээс татгалзсан, эсхүл эсэргүүцсэн бол албадлага хэрэглэнэ.

4. Цагдаагийн алба хаагч энэ зүйлийн 1.1-д заасан хохирогчид орон байрнаасаа хувцас, эм, эмчилгээний хэрэгсэл, баримт бичиг, хүүхдийн сургалтын хэрэгсэл зэрэг нэн шаардлагатай хэрэглээний эд зүйлээ авахад нь туслалцаа үзүүлж, хүчирхийлэл үйлдэгчээс шаардан гаргуулна.

5. Хүүхэд өөрийн хууль ёсны төлөөлөгчийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд аюулын эрсдэлийн зэрэг дунд болон өндөр, эсхүл дараахь нөхцөл тогтоогдвол хууль ёсны төлөөлөгчийн саналыг харгалзахгүйгээр хүүхдийг хамгаалах арга хэмжээг авна:

5.1. хүчирхийллийг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй бол;

5.2. хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй бол;

5.3. хүүхдийн эмзэг байдлыг далимдуулан өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй бол;

5.4. хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй бол;

5.5. хүчирхийлэл үйлдэгч согтуурсан, мансуурсан байдалтай, эсхүл байнга согтуурдаг, мансуурдаг бол.

---

4 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2013 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан хүүхдийг хамгаалах арга хэмжээг дараахь аргаар хэрэгжүүлнэ:

6.1.хамгаалах боломжтой хүн, гэр бүлд хүлээлгэн өгөх;

6.2.нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, эсхүл асрамж, халамжийн үйлчилгээний байгууллагад хүргэх.

7.Хүүхдийг энэ зүйлийн 6.1-д заасан хүнд хүлээлгэн өгөх бол түүнд эрх, үүргийг сануулж, бичгээр баталгаажуулна. Хохирогч хүүхэд долоо, түүнээс дээш настай бол хамгаалах боломжтой хүн, гэр бүлийг сонгохдоо түүний саналыг харгалзана.

#### **2.14 дүгээр зүйл. Иргэн, байгууллагаас ирсэн мэдээллийн дагуу ажиллах**

1.Цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор иргэн, байгууллагаас амаар болон холбоо, харилцааны хэрэгслээр мэдээллийг 24 цагаар хүлээн авна.

2.Цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээлэл утсаар хүлээн авахдаа өгч байгаа мэдээллийн талаархи нөхцөл байдал, мэдээлэл өгч байгаа хүний нэр, хаягийг тодруулах, боломжтой бол түүний хэлсэн зүйл шүүхэд нотлох баримтаар ашиглагдахыг хэлж, энэ талаар тэмдэглэлд тусгахаас гадна дууны бичлэгээр бэхжүүлж авч болно.

3.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээллийг хүлээн авч, энэ талаар мэдээлэл хүлээн авах нэгжид мэдэгдэн дараахь арга хэмжээг даруй авна:

3.1.гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох;

3.2.бусдын аюулгүй байдлыг хангах;

3.3.эрүүл мэндийн болон холбогдох бусад яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад мэдэгдэх;

3.4.хэргийн газрыг хамгаалалтад авах;

3.5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авах.

4.Цагдаагийн алба хаагч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан ажиллагаа явуулсан талаар тэмдэглэл үйлдэнэ.

5.Хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн талаархи мэдээллийг хүлээн авмагц таслан зогсоох арга хэмжээг даруй авна.

6.Хууль сахиулагч, эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээлэл хүлээн авч энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан ажиллагаа явуулна.

7.Эрүүл мэнд, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх явцад гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн байж болзошгүй гэж үзвэл нөхцөл байдлын талаар цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэж, энэ талаар тэмдэглэл үйлдэнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ**

### **3.1 дүгээр зүйл. Гамшиг, хорио цээрийн дэглэм тогтоосон үед нийтийн хэв журам сахиулах**

1. Хууль сахиулагч гамшиг, хорио цээрийн дэглэм тогтоосон үед дэглэм, нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор дараахь арга хэмжээг авна:

1.1. зөвшөөрөгдсөн цэг, зурвасаас бусад газраар хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй байх;

1.2. мэргэжлийн, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт, хөдөлгөөн хийлгэхгүй байх;

1.3. тухайн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа, хүн, ердийн хөсөг, авто болон төмөр замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хяналтад авч, зөвшөөрөл, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай баримтыг үндэслэн нэвтрүүлэх;

1.4. нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, хүн, мал, амьтны бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх;

1.5. шалган нэвтрүүлэх, эсхүл зорчигч, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх цэгүүдэд дэг журам сахиулах.

2. Хууль сахиулах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.

### **3.2 дугаар зүйл. Жагсаал, цуглааныг албадан тараах**

1. Цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг албадан тараахын өмнө оролцогчдод бүх төрлийн арга, холбооны хэрэгсэл ашиглан Засаг даргын жагсаал, цуглааныг албадан тараах тухай шийдвэрийг мэдэгдэж, биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн тохиолдолд авах арга хэмжээг урьдчилан анхааруулна.

2. Мэдэгдэл, шаардлага нь энэ хуулийн 1.8 дугаар зүйл, 2.1 дүгээр зүйлийн 3-т заасан шаардлагыг хангасан байна.

3. Албадан тараах ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн Тавдугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.

4.Албадан тараах ажиллагааны явцыг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулна.

### **3.3 дугаар зүйл.Нийтийн эмх замбараагүй байдлын үед авах арга хэмжээ**

1.Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч олон нийтийг хамарсан арга хэмжээний зорилго өөрчлөгдөж, нийтийн хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд тухайн үйл ажиллагааг зогсоох, тараах арга хэмжээ авахыг зохион байгуулагчаас шаардаж болно.

2.Цагдаагийн алба хаагч нийтийн эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараахь арга хэмжээг авна:

2.1.улсын онц чухал, хүн амын амьжиргааны хангамжийн объектын хамгаалалтыг хүч нэмэгдүүлэх, шаардлагатай бол галт тэрэг, нисэх онгоцны буудал, шатахуун түгээх газар, банк, бусад объектыг хамгаалалтад авах;

2.2.хүн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа галт зэвсэг, аюултай бодис, байлдааны техник хэрэгслийг хяналтад авах;

2.3.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, хэрэглэхийг хориглох;

2.4.хүн, тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, тээврийн хэрэгслийг шилжүүлэн байрлуулах;

2.5.нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж бусдад хүч хэрэглэсэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлсэн, эд хөрөнгө устгаж гэмтээсэн, эсхүл эдгээр үйлдэлд өдөөн турхирсан, татан оруулж болзошгүй хүмүүсийг албадан тараах;

2.6.согтуурсан, мансуурсан байдалтай хүнийг саатуулах, зэвсэг, техник хэрэгслийг хураан авах;

2.7.зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох бусад зүйлийг хууль бусаар авч яваа, хадгалж байгаа, эсхүл хэрэглэж болзошгүй хүний бие, тээврийн хэрэгсэл, эд зүйлд нэгжлэг хийх.

3.Нийтийг хамарсан арга хэмжээний үед хэвийн үйл ажиллагаа алдагдсан, хэв журмын нөхцөл байдал хүндэрснийг цагдаагийн байгууллага өөрийн хүч хэрэгслээр зохицуулах боломжгүй болсон тохиолдолд Терроризмтой тэмцэх тухай хуульд<sup>5</sup> заасны дагуу шуурхай штаб ажиллуулна.

### **3.4 дүгээр зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох**

---

5 Терроризмтой тэмцэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2004 оны 19 дугаарт нийтлэгдсэн.



1.Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох шийдвэрийг дараахь тохиолдолд гаргаж болно:

1.1.тухайн газрын ойролцоо нийтийн эмх замбараагүй байдал бий болсон, эсхүл болох үндэслэл байгаа;

1.2.нийтийн эмх замбараагүй байдлыг хяналтад авахад шаардлагатай гэж үзвэл.

2.Цагдаагийн алба хаагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийн дагуу тухайн газрыг түр хаах, эсхүл үйл ажиллагааг зогсоох, эсхүл тогтоосон бүсээс согтууруулах ундааны зүйлийг гаргах арга хэмжээ авна.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг хүн, хуулийн этгээд биелүүлнэ.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл арилсан бол шийдвэр гаргасан албан тушаалтан шийдвэрээ цуцалж, энэ тухай нийтэд мэдэгдэнэ.

### **3.5 дугаар зүйл.Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох**

1.Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга энэ 3.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл бий болсон бол нийтийн эзэмшлийн тодорхой бүсэд согтууруулах ундаа хэрэглэх, авч явахыг хориглох шийдвэр гаргаж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг зөрчсөн хүнийг тогтоосон бүсээс гарахыг шаардаж, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд албадан гаргахыг сануулна. Шаардлагыг биелүүлээгүй бол тогтоосон бүсээс албадан гаргана.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл арилсан бол шийдвэрийг цуцална.

### **3.6 дугаар зүйл.Хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх**

1.Хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч үндэслэл бүхий сэжиг байвал энэ хуулийн 3.1, 3.2, 3.3 дугаар зүйлд заасан ажиллагааны үед тогтоосон бүсэд байгаа хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг хийж болно.

2.Үзлэг хийхдээ тухайн хүний эд зүйл, биеийг гараар тэмтрэх, тусгай багаж ашиглах аргаар хийж болно.

3.Хүний биед үзлэг хийхэд өмссөн хувцас, биедээ авч яваа эд зүйлийг хамтад нь үзнэ.

4.Үзлэгийг тухайн нөхцөлд тохирсон хамгийн богино хугацаанд хийнэ.

5.Үзлэг хийх үед хуулиар хориглосон зүйл илэрвэл хураан ав

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛЬ САХИУЛАХ ТУСГАЙ АЖИЛЛАГАА**

### **4.1 дүгээр зүйл.Эрэн сурвалжлах ажиллагаа**

1.Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, тагнуулын байгууллага, Авлигатай тэмцэх газрын эрх бүхий алба хаагч дараахь хүн, хуулийн этгээд, эд зүйл, хөрөнгийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг шүүхийн шийдвэр, прокурорын даалгаврын дагуу, эсхүл хуульд заасан чиг үүргийн хүрээнд өөрөө санаачлан явуулна:

1.1.байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа төлбөр төлөгч, холбогдогч, гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй сэжиг бүхий хүн, сэжигтэн, яллагдагч;

1.2.оргон зайлсан холбогдогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ял шийтгүүлсэн хүн, хоригдол, ял оногдуулахыг тэнсэж албадлагын арга хэмжээ авагдсан хүн;

1.3.хулгайлагдсан, барьцаалагдсан хүн;

1.4.хэн болох нь тодорхойгүй цогцсыг тогтоох;

1.5.оршин суугаа газраасаа алга болсон хүн;

1.6.сураггүй алга болсон хүн;

1.7.эмнэлгээс оргосон сэтгэцийн өвчтэй хүн;

1.8.шүүхээс олж тогтоохыг даалгасан бусад хүн, хуулийн этгээд;

1.9.хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл.

2.Хүнийг эрэн сурвалжлах бол эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, гэрэл зураг, биеийн өндөр, жин, онцлох содон тэмдэг, нийтэд аюултай халдварт өвчнөөр өвчилсөн тухай, эрэн сурвалжлах үндэслэл зэрэг хуулиар хориглоогүй мэдээллийг олон нийтэд мэдээлж болно.

### **4.2 дугаар зүйл.Эрэн сурвалжлах нууц ажиллагаа**

1.Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, үйлдэгдсэн гэмт хэргийн талаархи мэдээлэл олж авах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Гүйцэтгэх ажлын тухай хуульд<sup>6</sup> заасан энгийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг эрэн сурвалжлах нууц ажиллагаа гэнэ.

2.Дараахь ажиллагаа нь эрэн сурвалжлах нууц ажиллагаанд хамаарна:

2.1.биечилсэн судалгаа хийх;

2.2.лавлагаа авах;

2.3.эд зүйлийг харьцуулан шинжлүүлэх;

---

6 Гүйцэтгэх ажлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

- 2.4.эд зүйл, баримт бичигт судалгаа хийх;
- 2.5.хэн болохыг тодорхойлох;
- 2.6.эрэн сурвалжлах нэвтрэлт;
- 2.7.эрэн сурвалжлах хяналтын худалдан авалт;
- 2.8.эрэн сурвалжлах хяналт тогтоох, ажиглалт явуулах;
- 2.9.эрэн сурвалжлах үзлэг хийх;
- 2.10.харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох;
- 2.11.эрэн сурвалжлах туршилт;
- 2.12.хяналттай хүргэлт.

3.Энэ зүйлийн 2.4, 2.5, 2.6-д заасан эрэн сурвалжлах нууц ажиллагааг байгууллагын удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр, энэ зүйлийн 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, 2.12-т заасан ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулна.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан прокурорын зөвшөөрөл авах ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.3 дугаар зүйлд заасан журмаар зохицуулна.

5.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрэн сурвалжлах нууц ажиллагаа явуулах журмыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Улсын ерөнхий прокурор батална.

6.Зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад заасан гэмт хэргийг илрүүлэхээс бусад үндэслэлээр цагдан хорих байранд эрэн сурвалжлах нууц ажиллагаа явуулахыг хориглоно.

7.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөвшөөрөл олгох явцад гэмт хэргийн шинжтэй нь тогтоогдвол прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээнэ.

8.Эрэн сурвалжлах нууц ажиллагаа, түүнийг гүйцэтгэх байгууллага, албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааны зарчим, эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрт тавих хяналттай холбогдсон бусад харилцааг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэх ажлын тухай хуулиар<sup>7</sup> зохицуулна.

#### **4.3 дугаар зүйл.Эрх бүхий байгууллага**

1.Дараахь байгууллага дор дурдсан тохиолдолд эрэн сурвалжлах нууц ажиллагаа гүйцэтгэнэ:

1.1.цагдаагийн байгууллага хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдол, прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, шүүх,

шүүгч, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйл, гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийг эрж олох;

1.2.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага яллагдагч, шүүгдэгч, хоригдол/цаашид хоригдол гэх/ оргох, хорих байгууллагад үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, эдгээргэмт хэргийн талаархи мэдээлэл олж авах, оргосон хоригдлыг баривчлах;

1.3.Авлигатай тэмцэх газар нь хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох;

1.4.тагнуулын байгууллага нь хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллага хуульд заасан ердийн арга хэрэгслээр шалгах боломжгүй тохиолдолд эрэн сурвалжлах нууц ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллага нь эрэн сурвалжлах нууц ажиллагаа гүйцэтгэх мэргэшсэн нэгжтэй байна.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллага нь эрэн сурвалжлах нууц ажиллагааны чиглэлээр мэдээллийн сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглана. Мэдээллийн сан нь төрийн нууцын зэрэглэлд хамаарна.

5.Энэ хуулийн 4.2 дугаар зүйлийн 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, 2.12-т заасан ажиллагааны үр дүнг эрүүгийн хэргийн нотлох баримтад тооцож болно.

6.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллагууд хамтран ажиллах журам, зааврыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Улсын ерөнхий прокурор батална.

#### **4.4 дүгээр зүйл.Хууль сахиулах тусгай ажиллагаа**

1.Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалт, тагнуулын байгууллага, Авлигатай тэмцэх газар хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад энэ хуульд заасан тохиолдолд нэмэлт хүч, тусгай тактик хэрэглэж хууль сахиулах тусгай ажиллагаа явуулж болно.

2.Дараахь байгууллага дор дурдсан тохиолдолд хууль сахиулах тусгай ажиллагаа гүйцэтгэнэ:

2.1.цагдаагийн байгууллага нь хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг

үүргээ хэрэгжүүлэх явцад нэмэлт хүч, тусгай тактик хэрэглэх зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн бол;

2.2.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хоригдол оргох, хорих байгууллагад үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх, бусдын амь насанд зэвсэглэн халдах зэрэг ноцтой гэмт үйлдлийг таслан зогсоох, бүлэглэн, зэвсэглэн оргосон этгээдийг баривчлах, хаалттай хорих ангийн харуул хамгаалалтын В, Г зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдлыг хуяглан хүргэх, хорих анги нүүлгэн шилжүүлэх үед;

2.3.төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь төрийн тусгай хамгаалалтад байгаа хүн, барилга, бусад зүйлийг барьцаанд авахаар завдсан үйлдлийг таслан зогсоох, барьцаанаас чөлөөлөх, төрийн тусгай хамгаалалтын бүсэд бий болсон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох үед нэмэлт хүч, тусгай тактик хэрэглэх зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн бол;

2.4.тагнуулын байгууллага нь тагнуул, сөрөх тагнуул, хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, терроризмтой тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэх явцад нэмэлт хүч, тусгай тактик хэрэглэх зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн бол;

2.5.Авлигатай тэмцэх газар нь хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэх явцад нэмэлт хүч, тусгай тактик хэрэглэх зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн бол.

3.Терроризмтой тэмцэх, онц болон дайны байдал зарласан, гамшигийн үед хэрэгжүүлэх хууль сахиулах тусгай ажиллагааг холбогдох хууль, энэ хуулиар зохицуулна.

4.Хууль сахиулах тусгай ажиллагааг цагдаа, төрийн тусгай хамгаалалт, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Авлигатай тэмцэх газар албаны алба хаагч, прокурорыг албан үүргээ гүйцэтгэж байгаа, гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан, түүнд болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд учрах аюулаас хамгаалах зорилгоор явуулж болно.

5.Хууль сахиулах тусгай ажиллагаанд ашиглах тусгай хэрэгсэл, галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тусгай техник хэрэгслийн жагсаалтыг Засгийн газар батална.

#### **4.5 дугаар зүйл.Хяналт тавих**

1.Энэ хуулийн 4.3 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан байгууллага нь эрэн сурвалжлах нууц ажиллагааны тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

2.Энэ хуулийн 4.3 дугаар зүйлд заасан байгууллагын ажиллагаанд тавих прокурорын хяналтыг Улсын ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор хэрэгжүүлнэ.

3.Прокурор эрэн сурвалжлах нууц ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.энэ хуулийн 4.3 дугаар зүйлийн 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, 2.12-т заасан эрэн сурвалжлах нууц ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэхийг хянах;

3.2.энэ хуулийн 4.3 дугаар зүйлийн 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, 2.12-т заасан эрэн сурвалжлах нууц ажиллагааны нэгдсэн бүртгэл, ашиглагдаж байгаа тусгай техник хэрэгслийн нэгдсэн тоо бүртгэлд хяналт тавих;

3.3.энэ хуулийн 4.3 дугаар зүйлийн 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, 2.12-т заасан эрэн сурвалжлах нууц ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгоход холбогдох баримт сэлтийг гаргуулж авах;

3.4.эрэн сурвалжлах нууц ажиллагааны явцад хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олгохоос татгалзах, тухайн ажиллагааны хугацааг сунгах, зогсоох;

3.5.эрэн сурвалжлах нууц ажиллагааны үр дүн, эрэн сурвалжлах нууц ажиллагааны холбогдох материалтай танилцах;

3.6.эрэн сурвалжлах нууц ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн, эрх бүхий байгууллагын ажилтан хууль тогтоомж зөрчсөн талаархи гомдлыг хянаж, буруутай этгээдэд хариуцлага тооцуулах арга хэмжээ авах;

3.7.энэ зүйлд заасан чиг үүргийн хүрээнд эрэн сурвалжлах нууц ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад хяналт, шалгалт явуулах.

4.Прокурорын зөвшөөрөл нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан ажиллагаа явуулах тухай эрэн сурвалжлах нууц ажиллагаа гүйцэтгэх байгууллагын шийдвэрийг батламжлах хэлбэрээр үйлдэгдэх бөгөөд шийдвэрт дараахь зүйлийг тодорхой тусгасан байна:

4.1.прокурорын зөвшөөрлөөр явагдах ажиллагааны төрөл, түүнийг явуулах үндэслэл, шаардагдах хугацаа, ашиглах тусгай техник хэрэгсэл;

4.2.прокурорын зөвшөөрлөөр явуулах ажиллагааны орон байр, бусад газар, шаардлагатай бусад мэдээлэл.

5.Эрэн сурвалжлах нууц ажиллагаа явуулсан байгууллага зохиосон арга хэмжээний үр дүнг зөвшөөрөл олгосон прокурорт танилцуулна.

6.Эрэн сурвалжлах нууц ажиллагаа, хууль сахиулах тусгай ажиллагаанд тавих дотоод хяналтыг харьяа байгууллагын дарга хэрэгжүүлнэ.

7.Тодорхой ажиллагаанд оролцсон нууц гүйцэтгэх ажилтан, туслах ажилтан, туслагч, халхавчийн байгууллага, ашигласан техник, арга хэрэгслийн талаархи мэдээлэл, үйл ажиллагаа нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарахгүй.

8.Энэ зүйлийн 3, 5 дахь хэсэгт заасан хяналт тавих хүрээнд нууц ажилтан, нууц мэдээлэгчийн талаархи материал хамаарахгүй.

## **ТАВДУГААР БҮЛЭГ АЛБАДЛАГА ХЭРЭГЛЭХ**

### **5.1 дүгээр зүйл.Хууль сахиулах ажиллагаанд албадлага хэрэглэх**

1.Энэ хуулиар эрх олгогдсон хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгч энэ хуулиар цагдаагийн алба хаагчид олгосон эрх хэмжээний хүрээнд биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хэрэглэж болно.

3.Хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагын даргын шийдвэрээр албан хэрэгцээнд хүлээн авч бүртгэсэн тусгай хэрэгсэл, галт зэвсэг, сум, бусад хэрэгслийг хууль сахиулах ажиллагаанд хэрэглэнэ.

4.Албадлага хэрэглэхийн өмнө боломжтой тохиолдолд урьдчилан сануулна.

5.Албадлагыг бусдыг гутаан доромжлох, цээрлүүлэх, шийтгэх зорилгоор, эсхүл албадлага хэрэглэх үндэслэл арилсан тохиолдолд үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно.

6.Хууль сахиулах ажиллагаанд хэрэглэх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг, сумны жагсаалт, тэдгээрийг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.Хууль сахиулах ажиллагаанд биеийн хүч, тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэх зааврыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

8.Албаны зориулалтаар шинээр галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник худалдан авах, албан хэрэгцээнд оруулахаас өмнө хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан танилцуулж, зөвшөөрөл авна.

9.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд, эрх бүхий албан тушаалтан биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх явцад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол эмнэлгийн байгууллагад мэдэгдэн, эрүүл мэндийн анхны тусламж үзүүлж, улмаар шууд захирах даргад, шууд захирах дарга нь прокурорт даруй мэдэгдэнэ.

## **5.2 дугаар зүйл.Тусгай хэрэгслийн төрөл**

1.Хууль сахиулах ажиллагаанд дараахь тусгай хэрэгсэл хэрэглэнэ:

- 1.1.нэг бүрийн;
- 1.2.олон хүнд нөлөөлөх;
- 1.3.бусад.

2.Хууль сахиулах ажиллагаанд нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар,уснаа явагч зэрэг тусгай хэрэгслээр тоноглогдсон тээврийн хэрэгсэл болон тээврийн хэрэгсэл албадан зогсоох, эвдэх хэрэгсэл, галт хэрэглэл, гэрэл, дууны хэрэгсэл, тусгай будагч, согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг шалгах хэрэгсэл, тээврийн хэрэгслийн хурд хэмжих хэрэгсэл, албаны нохой болон бусад тусгай хэрэгсэл ашиглаж болно.

3.Хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд, албан үүргээ гүйцэтгэхдээ хамгаалах тусгай хэрэгслээр хангагдана.

## **5.3 дугаар зүйл.Нэг бүрийн тусгай хэрэгсэл**

1.Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

- 1.1.гав;
- 1.2.хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл;
- 1.3.бороохой;
- 1.4.цахилгаан гүйдлээр цохигч;
- 1.5.нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;
- 1.6.резинэн ба хуванцар сумтай буу;
- 1.7.бусад тусгай хэрэгсэл.

2.Хуульд заасан чиг үүргийн хүрээнд гааль, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч энэ зүйлийн 1.3, 1.4, 1.5, 1.6-д заасан, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч энэ зүйлийн 1.1, 1.4, 1.5-д заасан, улсын хил хамгаалах байгууллагын алба хаагч энэ зүйлийн 1.1, 1.3, 1.4, 1.5, 1.6-д заасан, шийдвэр гүйцэтгэгч энэ зүйлийн 1.4, 1.5, 1.6-д заасан нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх эрхтэй.

3.Цагдаа, төрийн тусгай хамгаалалтын алба хаагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нэг бүрийн тусгай хэрэгслийг, тогтоол гүйцэтгэгч, хорих байгууллагын



албан хаагч энэ зүйлийн 1.7-д зааснаас бусад нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх эрхтэй.

#### **5.4 дүгээр зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх**

1. Нэг бүрийн тусгай хэрэгслийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

1.1. өөрийнх нь, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болох эрсдэлээс хамгаалах, таслан зогсоох;

1.2. гэмт хэрэг, зөрчлийн үйлдлийг таслан зогсоох, саатуулах, баривчлах;

1.3. хяналтад байгаа, саатуулагдсан, цагдан хоригдсон хүн, хоригдол амиа хорлох, өөрийн бие махбодид гэмтэл учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх;

1.4. сэтгэцийн эмгэг, санаа сэтгэл хүчтэй цочрон давчидсаны улмаас өөрийгөө удирдах чадваргүй, түүнчлэн согтуурсан, мансуурсан байдалтай, эсхүл догшин, хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаар бол;

1.5. цагдан хоригдсон хүн, хоригдол хорих байгууллагын алба хаагчид хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл албан хаагчийн аюулгүйн тойрогт зөвшөөрөлгүй нэвтэрсэн;

1.6. хууль сахиулагч, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд, эрх бүхий албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн;

1.7. саатуулах, баривчлах, хуяглан хүргэх, эрүүл мэндийн, эсхүл бусад эрх бүхий байгууллагад албадан хүргэх үед;

1.8. энэ хуульд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхээр заасан тохиолдолд.

2. Гааль, гадаадын иргэний хяналт, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч энэ зүйлийн 1.1, 1.2-т заасан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагч энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8-д заасан үндэслэлээр нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

3. Цагдаа, улсын хил хамгаалах байгууллагын алба хаагч, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч энэ зүйлийн 1.5-д зааснаас бусад үндэслэлээр нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

4. Дор дурдсанаас бусад тохиолдолд жирэмсэн, арван найман насанд хүрээгүй, бэртэл, гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно:

4.1.өөрийнх нь, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;

4.2.галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл эсэргүүцсэн;

4.3.амиа хорлож болзошгүй бол.

5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл үүссэн тохиолдолд хууль сахиулагч, эрх бүхий албан тушаалтан нэг бүрийн тусгай хэрэгслийг сонгож хэрэглэж болно.

6.Энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан этгээд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх явцад, эсхүл хэрэглэх бололцоогүй үед биеийн хүч хэрэглэж болно.

### **5.5 дугаар зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл**

1.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

- 1.1.олон хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч;
- 1.2.усан хөөрөг;
- 1.3.утаан хөшиг үүсгэгч;
- 1.4.олон хүнд нөлөөлөх бусад тусгай хэрэгсэл.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тусгай хэрэгслийг хуульд заасан чиг үүргийн хүрээнд цагдаа, төрийн тусгай хамгаалалтын алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэглэнэ.

### **5.6 дугаар зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх**

1.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухай шийдвэрийг хууль сахиулах байгууллагын дарга, түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан гаргана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрт хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дарааллын талаар заана.

3.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

3.1.өөрийнх нь, эсхүл бусад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар бүлэглэн довтолсон, эсэргүүцсэн;

3.2.төрийн тусгай хамгаалалтад байгаа, эсхүл хууль сахиулах ажиллагааг хэрэгжүүлэхбайгууллагын хамгаалалтад байгаа хүн, объектод бүлэглэн халдсан, халдахыг завдсан;

3.3.бусдын орон байр, эзэмшил газрыг бүлэглэн эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;

3.4.хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох гэмт хэргийг бүлэглэн үйлдэж байгааг таслан зогсоох, баривчлах;

3.5.галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн бүлэг зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;

3.6.нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хүч хэрэглэсэн жагсаал, цуглааныг албадан тараах үед;

3.7.бүлэглэн оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ял шийтгүүлсэн хүн, хоригдлыг баривчлах үед;

3.8.хорих анги, цагдан хорих байранд нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, эсхүл хорих байгууллагын аюулгүй байдалд хохирол учруулж болохоор үймээн гарсан.

4.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө дараахь арга хэмжээг авна:

4.1.тусгай хэрэгсэл хэрэглэх тухай анхааруулж, бүсээс даруй гарахыг анхааруулах;

4.2.тухайн бүсэд байгаа хүнийг бүсээс гарах талаар ухуулга хийх, хэрэглэх тусгай хэрэгслийн үйлчлэх нөлөөллийн талаар мэдээлэх;

4.3.яаралтай тусламж үзүүлэх мэргэжлийн байгууллагад мэдэгдэх.

5.Энэ зүйлийн 4.1-д заасан анхааруулгыг тусгай хэрэгслийн нөлөөлөлд өртөж болох хүмүүсийн дийлэнх хэсэгт хүргэх боломжтой бүх арга хэрэгслийг ашиглан зохион байгуулна.

6.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг энэ зүйлийн 4.1-д заасны дагуу анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй, шаардлагыг биелүүлээгүй, эсхүл хүний амь нас, эрүүл мэнд хохирох эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн бол шууд хэрэглэнэ.

7.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа ажиллагааг явуулсан байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран дараахь арга хэмжээг авна:

7.1.хордсон хүн, амьтан, тэсэрч дэлбэрэх, химийн болон аюултай хорт бодис алдагдах, гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж, аюулгүй болгох;

7.2.эмнэлгийн анхны туслалцаа үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах;

7.3.орчныг ариутгах, цэвэршүүлэх арга хэмжээ авах талаар холбогдох байгууллагад мэдэгдэх;

7.4.тусгай хэрэгслийн үйлчлэл дуусах, эсхүл үүссэн аюултай нөхцөл арилах хүртэл тухайн орчинд эргүүл, хамгаалалт гаргаж, зөвлөгөө, сануулга өгөх.

### **5.7 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл албадан зогсоох**

1.Цагдаа, төрийн тусгай хамгаалалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч тээврийн хэрэгслийг дараахь тохиолдолд албадан зогсооно:

1.1.өөрийнх нь, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болох бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан;

1.2.баривчлагдсан сэжигтэн, цагдан хоригдсон хүн, ял шийтгүүлсэн хүн, хоригдол тээврийн хэрэгсэл ашиглан зугтсан.

2.Улсын хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1.1-д заасан үндэслэлээр хилийн боомт, хилийн бүс, зурваст тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд автомашин, бусад зүйлээр хаалт тавьж тээврийн хэрэгслийг албадан зогсоож болно.

4.Тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг зорчих хөдөлгөөн ихтэй газар, олон нийтэд аюул учруулах эрсдэл байгаа үед хэрэглэхийг хориглоно.

### **5.8 дугаар зүйл.Албаны нохой ашиглах**

1.Хууль сахиулах ажиллагаанд албаны нохой ашиглаж болох ба албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан албаны нохойг бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй нөхцөл үүссэн, зэвсэглэсэн этгээд зугтаасан, довтолсноос бусад тохиолдолд хүний эсрэг ашиглахыг хориглоно.

### **5.9 дүгээр зүйл.Галт зэвсэг хэрэглэх үндэслэл**

1.Дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

1.1.өөрийнх нь, эсхүл бусад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон, тээврийн хэрэгсэл ашиглаж зугтаан орчиндоо аюул бий болгосон бол;

1.2.галт зэвсгийг булаахаар довтолсон бол;  
1.3.төрийн тусгай болон эрх бүхий байгууллагын хамгаалалтад байгаа хүн, бүс, объектод хууль бусаар нэвтэрсэн эсхүл завдсан, зэвсэг хэрэглэж, эсхүл бүлэглэн довтолсон бол;

1.4.хулгайлагдсан,барьцаанд байгаа хүнийг суллах бол;  
1.5.галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн бол;

1.6.хуяглан хүргэж яваа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ял шийтгүүлсэн хүн, хоригдлыг суллахаар зэвсэглэн довтолсон бол;

1.7.саатуулах, хорих, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүсч хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах нөхцөл байдал бий болсонбол;

1.8.бусдын албаны, эсхүл орон байранд зэвсэглэн, бүлэглэн довтолсон хүний дайралтыг таслан зогсоох, эзлэн авсныг чөлөөлөх бол;

1.9.нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед галт зэвсэг хэрэглэн довтолсон, эсэргүүцсэн бол;

1.10.зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг баривчлахбол;

1.11.саатуулагдсан, цагдан хоригдсон хүн, хоригдол оргон зугтсан, эсхүл оргохыг завдсан, зэвсэглэсэн хоригдлыг барих үед.

2.Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нь энэ зүйлийн 1.1, 1.2-т заасан үндэслэлээр галт зэвсэг хэрэглэнэ.

3.Цагдаагийн алба хаагч энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 1.10, 1.11-д заасан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагч энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.11-д заасан, улсын хил хамгаалах байгууллагын алба хаагч энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.5, 1.9, 1.10-т заасан, төрийн тусгай хамгаалалтын алба хаагч энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.9-д заасан үндэслэлээр галт зэвсэг хэрэглэнэ.

4.Галт зэвсгийг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор уршиг учруулж болзошгүй, эсхүл учруулж байгаа амьтныг устгах, түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах, бэлтгэл, сургуулилтын болон хуульд заасан бусад тохиолдолд хэрэглэж болно.

5.Галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэн эсэргүүцсэн, довтолсон, бүлэглэн дайрснаас бусад

тохиолдолд жирэмсэн, арван найман насанд хүрээгүй, бэртэл, гэмтэлтэй болох нь илэрхиймэдэгдэж байгаа хүний эсрэг галт зэвсэг хэрэглэхийг хориглоно.

### **5.10 дугаар зүйл. Галт зэвсэг хэрэглэх**

1. Галт зэвсэг хэрэглэх сургалтанд хамрагдан, эрх олгогдсон хууль сахиулагч, улсын хил хамгаалах байгууллагын алба хаагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч галт зэвсэг хэрэглэнэ.

2. Боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна. Сануулга өгөх нь цаг алдаж хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бодит эрсдэл үүссэн тохиолдолд шууд хэрэглэж болно.

3. Хууль сахиулагч галт зэвсэг хэрэглэхтэй холбоотой дараахь үүргийг хүлээнэ:

3.1. энэ хуулийн 5.9 дүгээр зүйлд заасан тохиолдол бий болсон үед галт зэвсгээ бэлэн байдалд авах;

3.2. тухайн хүнд галт зэвсэг хэрэглэх тухай сануулах, тодорхой зай байр тогтоох, хууль бус үйлдлээ зогсоохыг шаардах, эсхүл идэвхтэй үйлдэл хийхийг хориглох;

3.3. энэ зүйлийн 3.2-т заасны дагуу сануулсны дараа тухайн хүн үйлдлээ үргэлжлүүлсэн тохиолдолд галт зэвсэг хэрэглэх.

4. Хууль сахиулагч, улсын хил хамгаалах байгууллагын алба хаагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч галт зэвсэг хэрэглэсэн үндэслэл, хүний биед учирсан гэмтэл, үзүүлсэн тусламж, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдсэн тухай шууд захирах даргад даруй танилцуулж, бичгээр тайлбар үйлдэх бөгөөд шууд захирах дарга нь прокурорт мэдэгдэнэ.

5. Галт зэвсэг хэрэглэх сургалт зохион байгуулах, галт зэвсэг хэрэглэх эрх олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

### **6.1 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

1. Энэ хуулийг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг